

2025.04.30

№25/01

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 4 сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025.04.30

№25/02

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 болон 62.1.13 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 4 сарын 30-ны өдрийн хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр
 1. Чулууны Ганхуяг
 2. Бруно Рашле
 3. Авирын Сүхдорж
 4. Одончимэдийн Одбаяр
 5. Батбилэгийн Золбоо
 6. Михаил ЗелдовичХараат бус гишүүдээр
 1. Арно Вентура
 2. Мөнх-Очирын Сэргэлэн
 3. Роланд Нэш нарыг тус тус сонгосугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга (М.Энхзул)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025.04.30

№25/03

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны төсвийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх хэсэг, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 4 сарын 30 ны өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсвийг "Хавсралт 1"-ийн дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн хангаж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх болон Цалин, Урамшууллын хороонд, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн
2025 оны 4-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлын 03 тоот
тогтоолын нэгдүгээр хавсралт



Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны төсөв

(сая төгрөг)	Төсөв 2024	Гүйцэтгэл 2024	Гүйцэтгэл %	Төсөв 2025
ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал	358.0	368.4	102.9%	396.0
Томилолтын зардал	100.0	0.0	0.0%	30.0
Нийт	458.0	368.4	80.4%	426.0